

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 05 дугаар сарын 22 өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Чингэлтэй дүүргийн 13, 14, 15 дугаар хороодын Овооны орчмын тохижилтын 2 дугаар шатны ажил**

Тендер шалгаруулалтын дугаар: **ЧДХААА А18/001**

Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“Чингэлтэй дүүргийн 13, 14, 15 дугаар хороодын Овооны орчмын тохижилтын 2 дугаар шатны ажил”** -ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн материалыг цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50.000 /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны меркантын системийг ашиглан төлж 2018 оны 06 дугаар сарын 22 өдрийн 11 цаг 00 минутаас өмнө ирүүлнэ.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил /2016, 2017/-ийн дундаж нь 200 000 000 /хоёр зуун сая/ төгрөгөөс багагүй байна.
2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 85 000 000 /наян таван сая/ төгрөгөөс багагүй байна.
3. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жилийн /2016, 2017/ аль нэг жилд ядаж нэг удаа 200 000 000 /хоёр зуун сая/ төгрөгөөс багагүй үнийн дүнтэй гадна тохижилт, тоглоомын талбай хийх ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.
4. Шаардлагатай тусгай зөвшөөрөл: Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог: 2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, тохижилт

Тендерийн хамт 5 800 000 /таван сая найман зуун мянга/ төгрөгийн тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2018 оны 06 дугаар сарын 22 өдрийн 11 цаг 10 минутад нээнэ.

Дотоодын давуу эрхийн зөрүү: Тооцохгүй.

Гадаадын этгээд: Оролцох эрхгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, IV хороо, Ж.Самбуугийн гудамж-16, Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын II байр, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, Худалдан авах ажиллагааны алба, 511 тоот өрөө

Утас: 70110769